

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 07 сарын 16-ны
өдрийн 6905 дугаарт бүртгэв.

САНГИЙН САЙД БОЛОН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 06
сарын 07 өдөр

Дугаар А/105/239

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.14, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газар /Ч.Чимидсүрэн/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /М.Энхсайхан/-д, Кастодианы үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүдэд тус тус даалгасугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны ажлын алба /Т.Жамбаажамц/, Сангийн яамны Татварын бодлогын газар /Б.Тэлмүүн/-т тус тус үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

**ДОТООДЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ БОЛОН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД
НЭЭЛТТЭЙ АРИЛЖААЛСАН ЗАСГИЙН ГАЗАР, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БОЛОН
МОНГОЛ УЛСАД БАЙРЛАДАГ АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ӨРИЙН
ХЭРЭГСЭЛ /БОНД/, ХУВЬЦАА, БУСАД ҮНЭТ ЦААСЫГ БОРЛУУЛСНЫ
ОРЛОГОД АЛБАН ТАТВАР НОГДУУЛАХ ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ, СУУТГАН
ТООЦОХ, ТӨСӨВТ ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.14, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 20.5-д заасны дагуу дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан Засгийн газар, аймаг, нийслэлийн болон Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл (бонд), хувьцаа, бусад үнэт цаас (цаашид “Үнэт цаас” гэх)-ыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмын 1.1-д заасан харилцааг зохицуулахад Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ журмыг мөрдлөг болгоно.

1.3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.5-д заасан хөрөнгө борлуулсны орлого олох үйл ажиллагаа эрхэлдэг албан татвар төлөгчид энэ журам хамаарахгүй.

Хоёр.Үнэт цаасны арилжаанд оролцогч, түүний мэдээллийг бүртгэх

2.1.Үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг тодорхойлох, суутган төлөх, тайлагнахтай холбоотой харилцаанд дараах талууд оролцоно:

2.1.1.үнэт цаасны арилжаанд оролцогч;

2.1.2.үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд;

2.1.3.кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд;

2.1.4.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага;

2.1.5.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага;

2.1.6.үнэт цаасны клирингийн байгууллага;

2.1.7.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.

2.2.Энэ журмын хүрээнд албан татвар суутган төлөгч гэж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг хэлнэ.

2.3.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь дараах мэдээллийг үнэт цаасны арилжаанд оролцогчоос гаргуулан авч, албан татвар суутган төлөгчид цахим хэлбэрээр хүргүүлнэ:

2.3.1.үнэт цаасны арилжаанд оролцогч нь хөгжлийн бэрхшээлтэй бол хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тодорхойлсон холбогдох баримт бичиг;

2.3.2.Татварын ерөнхий хуулийн 6.1.16-д заасан баримт бичиг.

2.4.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь энэ журмын 2.3-д заасан мэдээллийг тухай бүр шинэчлэн бүртгэнэ.

2.5.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь үнэт цаасны арилжаанд оролцогчийн үнэт цаас худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн шимтгэлийн дүнгийн мэдээллийг тухай бүр албан татвар суутган төлөгчид цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.6.Үнэт цаасны арилжаанд оролцогч нь үнэт цаасаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь нэрийн данснаас кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн данс руу шилжүүлж байгаа тохиолдолд кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь энэ журмын 2.5-д заасан мэдээллийг үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

2.7.Үнэт цаасны арилжаанд оролцогч нь үнэт цаасаа кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн данснаас үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь нэрийн данс руу шилжүүлж байгаа тохиолдолд кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь энэ журмын 2.5-д заасан мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргаж өгнө.

2.8.Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь дараах мэдээллийг албан татвар суутган төлөгчид цахимаар хүргүүлнэ:

2.8.1.үнэт цаас гаргагчийн Монгол Улсад үл хөдлөх хөрөнгөтэй эсэх мэдээлэл;

2.8.2.тухайн өдрийн үнэт цаасны арилжааны дараах ханшийн мэдээлэл;

2.8.3.үнэт цаасны ханшийн түүхэн мэдээлэл.

2.9.Энэ журмын 2.8.1-д заасан мэдээллийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь жил бүр шинэчилж бүртгэнэ.

Гурав. Татвар ногдуулах орлогыг тодорхойлох

3.1.Албан татвар суутган төлөгч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.3, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.1.3-д заасны дагуу үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг суутган ногдуулахдаа энэ журмын хавсралтад заасан жигнэсэн дундаж өртгийн аргыг баримтална.

3.2.Худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүн нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан шаардлагыг хангасан, төлбөрийн баримтаар баталгаажсан байна.

3.3.Албан татвар суутган төлөгч нь үнэт цаас худалдан авахад төлсөн шимтгэлийн дүнг үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

3.4.Үнэт цаасны арилжаанд оролцогчийн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөхөөс өмнөх хугацаанд үнэт цаас худалдан авахад төлсөн шимтгэлийн дүнг тухайн шимтгэлийг төлсөн баримтад үндэслэн татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

3.5.Үнэт цаасны арилжаанд оролцогч нь өөр төрлийн үнэт цаасаар хөрвүүлэх байдлаар эзэмшсэн үнэт цаасыг борлуулсан тохиолдолд хөрвүүлэг хийгдсэн үнэлгээ, ханшийг худалдан авсан үнэ гэж үзнэ.

3.6.Компанийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах зэргээр компанийг өөрчлөн байгуулсны улмаас үүссэн үнэт цаасыг борлуулсан бол худалдан авсан үнийг өөрчлөн байгуулалт хийгдсэний дараах үнэт цаасны үнэлгээнээс тодорхойлно.

3.7.Хувьцааг нэгтгэх, эсхүл хуваах зэргээр үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсноор үүссэн үнэт цаасыг борлуулсан бол худалдан авсан үнийг өөрчлөн байгуулалт хийгдсэний дараах үнэт цаасны үнэлгээнээс тодорхойлно.

Дөрөв. Албан татварыг суутган тооцох, төсөвт төлөх

4.1. Албан татвар суутган төлөгч нь хувь хүний үнэт цаас борлуулсны орлогод дараах хувь хэмжээгээр татвар ногдуулан суутгана:

4.1.1. Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.2.4-т заасан хувь хэмжээгээр;

4.1.2. Монгол Улсад байнга оршин суугч бус албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.2.5-д заасан хувь хэмжээгээр.

4.2. Албан татвар суутган төлөгч нь аж ахуйн нэгжийн үнэт цаас борлуулсны орлогод дараах хувь хэмжээгээр татвар ногдуулан суутгана:

4.2.1. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч болон төлөөний газраар бүртгүүлсэн Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.1-д заасан хувь хэмжээгээр;

4.2.2. энэ журмын 4.2.1-д зааснаас бусад Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.4-т заасан хувь хэмжээгээр.

4.3. Албан татвар суутган төлөгч нь энэ журмын 4.1, 4.2-т заасны дагуу суутгах албан татварт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.17 болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.17-д заасан хөнгөлөлттэй хувиар ногдуулж, суутгана.

4.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.7-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгжид энэ журмын 4.3-т заасан хөнгөлөлт хамаарахгүй.

4.5. Монгол Улсад байнга оршин суугч бус, эсхүл Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч нь Монгол Улсаас гадаад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээр” /цаашид “Давхар татварын гэрээ” гэх/-тэй улсын байнга оршин суугч, эсхүл тухайн улсад байрладаг албан татвар төлөгч бол гэрээний холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

4.6. Монгол Улсад байнга оршин суугч бус, эсхүл Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод татвар ногдуулан тооцохдоо албан татвар суутган төлөгч нь Давхар татварын гэрээний заалтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.6.1.Давхар татварын гэрээнд албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод хэлэлцээр байгуулагч нөгөө улс татвар ногдуулахаар заасан тохиолдолд албан татвар суутган төлөгч нь татвар ногдуулахгүй;

4.6.2.Давхар татварын гэрээнд албан татвар төлөгчийн үнэт цаас борлуулсны орлогод Монгол Улс татвар ногдуулахаар заасан тохиолдолд энэ журмын 4.1.2, 4.2.2-т заасан хувь хэмжээгээр татварыг ногдуулж, суутган төлнө;

4.6.3.Давхар татварын гэрээний заалтыг дагаж мөрдөх тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцогч нь дараах баримт бичгийг албан татвар суутган төлөгчид гаргаж өгнө:

4.6.3.1.татварын зорилгоор оршин суугчийн татварын гэрчилгээ;

4.6.3.2.үнэт цаасны арилжаанд оролцогчийн “Төлөөний газар байгуулахгүйгээр Монгол Улсад бизнес эрхлэгч гадаад улсын оршин суугчийн олсон орлогод бууруулсан хувь хэмжээгээр албан татвар ногдуулах” тухай ДТ-01 маягт.

4.7.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны арилжаанд оролцогчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварын дүнг энэ журмын 2.1.2, 2.1.5-д заасан этгээдээс хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн тодорхойлж үнэт цаасны клирингийн байгууллагад цахимаар хүргүүлнэ.

4.8. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь өөрийн харилцагч үнэт цаасны арилжаанд оролцогчийн үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах албан татварын дүнг энэ журмын 2.1.2, 2.1.6-д заасан этгээдээс хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн тодорхойлно.

4.9.Үнэт цаасны клирингийн байгууллага нь энэ журмын 4.7-д заасан мэдээллийн дагуу төлбөр хийгдэх бэлтгэлийг ханган, төлбөр гүйцэтгэх даалгаврыг албан татвар суутган төлөгчид цахимаар хүргүүлнэ.

4.10.Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь өөрийн харилцагч хувь хүн, аж ахуйн нэгжийн, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн харилцагчдаас бусад хувь хүн, аж ахуйн нэгжийн үнэт цаас борлуулсны орлогод албан татварыг ногдуулж, суутган, төсөвт төлнө.

4.11.Албан татвар суутган төлөгч нь хувь хүний үнэт цаас борлуулсны орлогод суутган ногдуулсан албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор, аж ахуйн нэгжийн үнэт цаас борлуулсны орлогод суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 өдрийн дотор тус тус төсөвт шилжүүлнэ.

4.12.Энэ журмын 4.11-д заасны дагуу албан татвар суутган төлөгч нь хувь хүн, аж ахуйн нэгжийн үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг суутгахдаа үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо бүрэн хийгдэж дууссан өдрөөс хойш эхлэн тооцно.

4.13.Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд зөвшөөрсөн тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн харилцагчдын татварыг суутгах, төлөх, тайлагнах үүргийг хэрэгжүүлж болно.

4.14.Албан татвар суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахдаа Татварын ерөнхий хуулийн 10.2-т заасан журмын дагуу холбогдох нотлох баримтыг үндэслэн албан татвараас чөлөөлнө.

Тав. Албан татварыг тайлагнах

5.1.Албан татвар суутган төлөгч нь хувь хүний үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулан суутгасан албан татварын тайланг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27.1-д заасны дагуу харьяа татварын албанд хүргүүлнэ.

5.2. Албан татвар суутган төлөгч нь аж ахуйн нэгжийн үнэт цаас борлуулсны орлогод албан татвар ногдуулан суутгасан албан татварын тайланг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26.5-д заасны дагуу харьяа татварын албанд хүргүүлнэ.

Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан засгийн газар, аймаг, нийслэлийн болон монгол улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журмын хавсралт

ЖИГНЭСЭН ДУНДАЖ ӨРТГИЙГ ДАРААХ ТОМЬЁОЛЛЫН ДАГУУ ТООЦООЛНО:

$$1. AY = \frac{Y_1YT_1 + Y_2YT_2 + \dots + Y_{n-1}YT_{n-1} + Y_nYT_n}{YT_1 + YT_2 + \dots + YT_{n-1} + YT_n}$$

Тухайн үнэт цаасыг эзэмшиж буй нийт хугацаанд үнэт цаас худалдан авахад зарцуулсан нийт үнийг үнэт цаасны тоо ширхэгт хувааж нэгжийн дундаж өртгийг тодорхойлно.

$$2. T = [(3Y - AY) * YT - ш] * t$$

Арилжаалсан нэгжийн үнээс нэгжийн дундаж өртгийг хасаж, баримтаар нотлогдох шимтгэлийн дүнг хасна. Тус дүнгээс суутган тооцох татварын хувь хэмжээгээр албан татварыг суутгана.

Тайлбар:

ЗҮ - зарсан үнэ

АҮ - авсан үнэ

ҮТ - зарсан үнэт цаасны тоо

n - арилжааны тоо

ҮТ_n - арилжаа бүрийн авсан үнэт цаасны тоо

ҮТ_n - арилжаа бүрийн үнэт цаасны үнэ

ш-шимтгэл

t-татварын хувь

T-суутган тооцох татварын дүн

Жишээ 1

Иргэн Б "Х" ХК-ийн хувьцааг 1011 төгрөгөөр 50 ширхэг, 1027 төгрөгөөр 50 ширхгийг худалдан авсан. Дараа нь уг хувьцааны ширхэг бүрийг 1030 төгрөгөөр зарсан ба үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(1011\text{₮} * 50 + 1027\text{₮} * 50) / (50 + 50) = 1019\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[1011\text{₮} * 50 + 1027\text{₮} * 50] * 0.01 = 1019\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(1030\text{₮} * 100 - 1019\text{₮} * 100) - 1019\text{₮}] * 10\% = 18\text{₮}$

Жишээ 2

Иргэн Б "Х" ХК-ийн хувьцааг 1011 төгрөгөөр 50 ширхэг, 1027 төгрөгөөр 50 ширхгийг худалдан авсан. Дараа нь уг хувьцааны ширхэг бүрийг 1010 төгрөгөөр зарсан ба үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(1011\text{₮} \cdot 50 + 1027\text{₮} \cdot 50) / (50 + 50) = 1019\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[1011\text{₮} \cdot 50 + 1027\text{₮} \cdot 50] \cdot 0.01 = 1019\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(1010\text{₮} \cdot 100 - 1019\text{₮} \cdot 100) - 1019\text{₮}] \cdot 10\% = (-146.9\text{₮})$ буюу татвар төлөхгүй.

Жишээ 3

Иргэн Б "Х" ХК-ийн хувьцааг 1011 төгрөгөөр 50 ширхгийг өмнөх онд үнэт цаасны компанийн шимтгэл 3 хувь байхад худалдан авсан. Энэ онд 1027 төгрөгөөр 50 ширхгийг үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь байхад худалдан авсан. Дараа нь уг хувьцаагаа нэг бүр нь 1040 төгрөгөөр зарсан, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(1011\text{₮} \cdot 50 + 1027\text{₮} \cdot 50) / (50 + 50) = 1019\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[1011\text{₮} \cdot 50] \cdot 0.03 + [1027\text{₮} \cdot 50] \cdot 0.01 = 2030\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(1040\text{₮} \cdot 100 - 1019\text{₮} \cdot 100) - 2030\text{₮}] \cdot 10\% = 7\text{₮}$

Жишээ 4

Иргэн А "Х" ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг хувьцааг эзэмшдэг. Харин "Х" ХК нь "Ү" хаалттай ХК-тай нэгдэж "Ү" нээлттэй ХК нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцаагаа олон нийтэд гаргасан тул Иргэн А 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг хувьцаатай болсон. Тэрээр нэрлэсэн үнэ нь 1050 төгрөгийн үнэтэй болоход зарсан ба үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(1000\text{₮} \cdot 100) / 100 = 1000\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[100\text{₮} \cdot 100] \cdot 0.01 = 100\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(1050\text{₮} \cdot 100 - 1000\text{₮} \cdot 100) - 100\text{₮}] \cdot 10\% = 490\text{₮}$

Жишээ 5

Иргэн Б "Х" ХК-ийн 1011 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 ширхэг хувьцааг өмч хувьчлалаар эзэмшдэг, 1027 төгрөгөөр 50 ширхгийг худалдан авсан. Дараа нь уг хувьцааны ширхэг бүрийг 1030 төгрөгөөр зарсан ба үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(0\text{₮} \cdot 50 + 1027\text{₮} \cdot 50) / (50 + 50) = 513.5\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[1027\text{₮} \cdot 50] \cdot 0.01 = 513.5\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(1030\text{₮} \cdot 100 - 513.5\text{₮} \cdot 100) - 513.5\text{₮}] \cdot 10\% = 5,113.65\text{₮}$

Жишээ 6

Иргэн А "Х" ХК-ийн нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг хувьцааг эзэмшдэг. Харин "Х" ХК нь нэгж хувьцаагаа 10 хувааж 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцаагаа олон нийтэд гаргасан тул Иргэн А 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1000 ширхэг хувьцаатай болсон. Тэрээр нэрлэсэн үнэ нь 150 төгрөгийн үнэтэй болоход зарсан ба үнэт цаасны компанийн шимтгэл 1 хувь, татварын хувь хэмжээ 10 хувь бол жигнэсэн дундаж өртөг, үнэт цаасны компанийн шимтгэл болон татвар төлөгдөх дүн дараах байдлаар тооцогдоно:

Жигнэсэн дундаж өртөг: $(100\text{₮} \cdot 1000) / 1000 = 100\text{₮}$

Үнэт цаасны компанийн шимтгэл: $[1000\text{₮} \cdot 100] \cdot 0.01 = 1000\text{₮}$

Татвар төлөгдөх дүн: $[(150\text{₮} \cdot 1000 - 100\text{₮} \cdot 100) - 1000\text{₮}] \cdot 10\% = 1390\text{₮}$